

“Монос” дээд сургуулийн Захирлын

2012 оны 08 сарын 27 –ны өдрийн

93 тоот тушаалын арван хоёрдугаар хавсралт

## **“МОНОС” ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ДОТУУР**

### **БАЙРНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг . Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар “Монос” дээд сургуулийн оюутнуудыг оюутны дотуур байр /цаашид байр гэх/-нд суулгахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. “Монос” дээд сургууль нь оюутны хэвийн амьдрах нөхцлийг бүрдүүлэн байрны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна. “Монос” дээд сургуулийн оюутны дотуур байрны төлбөрийг сургуулийн удирдах зөвлөл жил бүр батална.
- 1.3. Байранд суух оюутантай үүсэх харилцааг энэхүү журам болон гэрээгээр зохицуулна.
- 1.4. Байранд суух оюутан нь орон нутгаас элссэн “Монос” дээд сургуулийн оюутан байна.
- 1.5. Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй оюутныг дотуур байранд эхний ээлжинд оруулна.

Хоёр. Бүртгэх ажиллагаа

- 2.1. Оюутны алба нь дотуур байранд орох хүсэлт гаргасан оюутныг бүртгэхтэй холбогдуулан дараах үүргийг хүлээнэ.
  - 2.1.1. Энэхүү журмын 1.4-д заасан шалгуур болон хяналтын тоог үндэслэн оюутныг бүртгэнэ.
  - 2.1.2. Бүртгэлийн дүнг тухай бүр нь сургуулийн удирдлагад танилцуулна.
  - 2.1.3. Бүртгэл хийхдээ Оюутны иргэний үнэмлэх, Эрүүл мэндийн үзлэгийн хуудас, байрны төлбөрийн баримт бичгийг үндэслэн бүртгэнэ.

Гурав. Оюутныг байранд байрлуулах

- 3.1. Оюутны албаны эрхлэгч нь дотуур байранд суух оюутан нэг бүртэй гэрээ байгуулна.

- 3.2. Оюутныг байранд суулгах хуваарь гарган байрлуулна.
- 3.3. Оюутан бүрт энэхүү журам болон бусад холбогдох журам зааврыг танилцуулна .
- 3.4. Оюутан тавилга, эд хогшлыг бүртгэлийн картаар олгож, өрөөний түлхүүр олгоно.

Дөрөв. Оюутны байрны өдөр тутмын үйл ажиллагаа

- 4.1. Байрны өдөр тутмын үйл ажиллагааг тухайн байрны багш хариуцаж, байнгын хяналт тавина.
- 4.2. Энэхүү журам болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн оюутны асуудлыг Оюутны албаны эрхлэгч, байрны багш нар хэлэлцэж, сануулах, байранд суух гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 4.3. Дотуур байранд орон нутгаас ирсэн оюутны эцэг, эх, ойрын төрөл, садны хүмүүсийг байрны багшийн зөвшөөрлөөр зөвхөн өдрийн цагаар нэвтрүүлнэ.
- 4.4. Оюутны байранд дараах үйлдэл хийхийг хатуу хориглоно:
  - 4.4.1. Оюутан 22.30 цагаас хойш байранд орох, гарах
  - 4.4.2. Оройн 22.30 цагаас хойш сэлгүүцэх, хөгжим, телевиз, радио чангаар тавих зэргээр бусдын тайван байдлыг алдагдуулах
  - 4.4.3. Согтууруулах, мансууруулах зүйл хэрэглэх, нийгмийн хэв журам зөрчих, хуулиар хориглосон бусад үйлдэл болон гадны хүн зүй бусаар орогнуулах
  - 4.4.4. Байрны эд хогшлыг байрны багшийн зөвшөөрөлгүй гадагш гаргах, гаднаас оруулах, хоорондоо солилцох
  - 4.4.5. Худалдаа үйлчилгээ явуулах, арилжааны зориулалттай эд зүйл, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис оруулах, хадгалах, амьтан тэжээх
  - 4.4.6. Тасагт 1 кВт-аас дээш чадалтай цахилгааны хэрэгслэл болон стандартын бус залгуур хэрэглэх, нийтийн бие засах газрын суултуур, угаагуурт бүхэл хог хаягдал хийх

Тав. Байрны гэрээ сунгах, дуусгавар болгох, цуцлах

- 5.1. Энэхүү журам болон гэрээний үүргээ зөрчөөгүй тохиолдолд гэрээг сунгана.
- 5.2. Гэрээнд заасан хугацаа дууссанаар байранд суух гэрээ дуусгавар болно.
- 5.3. Гэрээг дараах тохиолдолд цуцлана.
  - 5.3.1. “Монос” дээд сургуулийн захирлын тушаалаар сургуулиас хасагдсан болон тодорхой хугацаагаар чөлөө авсан.

5.3.2. Энэхүү журмын 4.4 дэх заалтыг зөрчсөн

5.5. Энэхүү журмын 4.4 дэх заалтаар гэрээ нь цуцлагдсан оюутны байрны төлбөрийг эргүүлэн олгохгүй ба бусад тохиолдолд захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн шийдвэрлэнэ.

5.6. Гэрээ дуусгавар болсон тохиолдолд оюутан нь тавилга, эд хогшлоо бүртгэлийн картын дагуу байрны багшид хүлээлгэн өгөх бөгөөд үрэгдүүлсэн эд хогшлыг нөхөн төлнө.

Зургаа. Санал, хүсэлт, гомдол хүлээн авах шийдвэрлэх

6.1. Байрны өдөр тутмын ажил, үйлчилгээний талаар оюутны гаргасан санал, хүсэлтийг байрны багш хүлээн авна.

6.2. Санал, хүсэлт, гомдлыг хүлээн авсан албан тушаалтан уг асуудлыг 3-10 хоногийн дотор хянан шийдвэрлэх эсхүл сургуулийн захиргаанд уламжлан шийдвэрлүүлнэ.